ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГААЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРООНЫ 4 ДЭХ УУЛЗАЛТЫН НЭЭЛТИЙН АЖИЛЛАГААНД САНГИЙН САЙДЫН ХЭЛЭХ ҮГ

Улаанбаатар хот, 2005 оны 9 дүгээр сарын 7-9-ний өдрүүд

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,
Ноёд хатагтай нар аа,

Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Гаалийн хамтын ажиллагааны хорооны 4 дэх удаагийн уулзалт энэ удаа Улаанбаатар хотноо зохион байгуулагдах гэж байна. Та бүгдийг Монгол Улсад, мөн энэхүү Гаалийн хамтын ажиллагааны хорооны 4 дэх удаагийн уулзалтад тавтай морилохыг хүсье.

Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Азийн хөгжлийн банк болон Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн нэгж энэхүү уулзалтыг Монгол Улсад зохион байгуулж байгаад гүн талархлаа илэрхийлж байна.

Мөн, энэ завшааныг ашиглан, Азийн хөгжлийн банкны зүгээс Төв Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа, тэр дундаа бүс нутгийн хэмжээнд худалдааны бодлогын шинэчлэлт, гадаад худалдааг хөнгөвчилсөн зохицуулалтыг уялдуулах, гаалийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд байнга дэмжлэг туслалцаа үзүүлж байдагт гүнээ талархаж байдгаа илэрхийлэхийг хүсч байна.

Бид бүгд даяарчлалын эрин зуунд амьдарч байгаа билээ. Өнөө үед дэлхийн зах зээлд эргэлдэж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын хэмжээ өдрөөс өдөрт нэмэгдэж, төрөл хэмжээ ч тасралтгүй өргөжиж байна. Энд ганцхан жишээ дурьдахад, дэлхийн нэг өдрийн гадаад валютын худалдааны эргэлт 2 триллион ам.долларт хүрээд байна. Энэхүү асар хурдацтайгаар өөрчлөгдөж буй

дэлхийн эдийн засгийн шинэ нөхцөлд далайд гарцгүй, хөгжиж буй манай орнуудын хувьд бүс нутгийн түвшинд худалдааны бодлогоо уялдуулж худалдааг хөнгөвчлөх, ялангуяа гаалийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нь ихээхэн чухал ач холбогдолтой билээ. Энэхүү салбарт хамтран ажиллах нь Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн шилжилтийг түргэсгэж, эдийн засгийн өсөлтийг бий болгон ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэх юм. Иймээс ч Монгол Улсын Засгийн газар гадаад худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдол өгч байгаа бөгөөд гаалийн мэдээллийг төвлөрүүлж, төрийн байгуллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн электрон сүлжээнд нэгтгэх "Нэг элетрон цонх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтуудыг тавьж ажиллаж байна.

Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид өө,
Ноёд хатагтай нар аа,

Энэ удаагийн уулзалтад Төв Азийн бүс нутгийн бүх Гаалийн байгууллагуудын төлөөлөл хүрэлцэн ирээд байна. Энэ нь бүс нутгийн хэмжээнд тулгамдаад байгаа салбарын чухал асуудлуудын талаар санал солилцохоос гадна харилцан туршлага солилцох, бие биенээсээ суралцах сайхан боломжийг олгож байгаа билээ.

Энэхүү уулзалтаар та бүхэн Төв Азийн гаалийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлуудын талаар, мөн Гадаад худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийн явцын талаар үр дүнтэй санал солилцож, ирэх оны ажлын төлөвлөгөөгөө батлахад дэмжлэг болно хэмээн найдаж байна.

Та бүхэнд амжилт хүсье.

Баярлалаа.